



МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ

2023 оны 09 сарын 26 өдөр

Дугаар А/390

Улаанбаатар хот

Хууль хэрэгжүүлэх зарим  
арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.7 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдыг 2023-2024 оны хичээлийн жилд сурах бичгээр бүрэн хангах арга хэмжээ авч ажиллахыг Боловсролын ерөнхий газар (Т.Ням-Очир)-т үүрэг болгосугай.

2. Суралцагчдын эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нарын шинэ сурах бичиг худалдан авах хүсэлтэд тулгуурлан ерөнхий боловсролын дунд, ахлах ангийн сурах бичгийг хэвлэсэн өртөг, тээврийн зардлыг хамтатган тооцож худалдах, цахим хэлбэрээр захиалга авах, тооцоо хийх боломжийг холбогдох хуулийн этгээдтэй хамтран хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж ажиллахыг Боловсролын ерөнхий газар (Т.Ням-Очир)-т зөвшөөрсүгэй.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ерөнхий боловсролын бодлого, удирдлага, зохицуулалтын газар (Б.Гантулга), Салбарын хяналтын газар (Л.Төгсбаяр)-т тус тус даалгасугай.

САЙД



Л.ЭНХ-АМГАЛАН

14231 1504